



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 26.

Есөнбулаг сум

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, 20.1.14 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын гавьяат хуульч, Төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх, хурандаа генерал, Монгол Улсын харцага, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Жарантайн Авхиагийн гавьяат үйлсийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх зорилгоор аймгийн Цагдаагийн газрыг Ж.Авхиагийн нэрэмжит болгосугай.

2. Аймгийн Цагдаагийн газрыг Монгол Улсын гавьяат хуульч, Төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх, хурандаа генерал, Монгол Улсын харцага, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Авхиагийн нэрэмжит болгосонтой холбогдуулан түүний гавьяат ажил үйлсийг залуу хойч үеийнхэнд таниулж, алдаршуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/ –д даалгасугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ

